



АЙМАГ, ДҮҮРЭГ (НИЙСЛЭЛ)-ИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
(ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.
Хуульчдын гудамж 13/1. Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2014.06.04 № 1/901.
танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай

“Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль” болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2014 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Ажилгүйдлийн тэтгэмж тооцох, сургалтын зардал олгох журам” (цаашид “журам” гэнэ)-ын дагуу ажилгүйдлийн тэтгэмж тооцох, сургалтын зардал олгохдоо дараах чиглэл баримталж ажиллахыг үүрэг болгож байна. Үүнд:

Нэг. Ажилгүйдлийн тэтгэмж авах эрхийн талаар:

1.1. “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 7-д заасныг үндэслэн улирлын чанартай ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага (ажил олгогч)-аас нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлсөн, шимтгэл төлсөн нийт хугацаа нь “Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай” хуулийн 2 дугаар зүйлд заасан болзол нөхцөлийг хангаж буй, ажил олгогчтойгоо хөдөлмөрийн гэрээ цуцалсан даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүснэ. Харин сул зогсолтын үед хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шимтгэл төлсөн, энэ дүнг ажилгүйдлийн тэтгэмж бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнд даатгуулагч хүсэлт гаргаагүй бол оруулахгүй.

Хоёр. Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээний талаар:

2.1. Даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмжийг тооцоход тухайн үед мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас бодсоноос бага гарвал “Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 2-т заасныг баримтална.

Тухайлбал, даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан сүүлийн 3 сарын цалингийн дундаж 200 000 төгрөг, шимтгэл төлж ажилласан хугацаа 4 жил, өөрийн хүсэлтээр халагдсан гэвэл, даатгуулагчид олгох ажилгүйдлийн тэтгэмжийн бодит хэмжээ 169 811.3 төгрөг (200 000 төгрөг х 45% : 21.2 х 40 хоног) байна. Энэ дүн нь тухайн үед мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас бодсон дүнгээс бага байгаа тул уг даатгуулагчид 271 680 (192 000 төгрөг х 75% : 21.2 х 40 хоног) төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг тооцож олгоно.

Гурав. Ажилгүйдлийн тэтгэмжийн хугацааны талаар:

3.1. Ажилгүйдлийн тэтгэмж тооцож эхлэх хугацаа нь “Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлд “... бүртгүүлсний дараагийн өдрөөс” гэж, мөн Монгол Улсын Дээд шүүхийн 2008 оны 47 дугаар тогтоолын 3.2 дахь хэсэгт “... ажилгүйдлийн тэтгэмж авах, мэргэжлийн сургалтад хамрагдах эрх ажлаас халагдсан даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлснээр үүснэ” гэж тус тус журамласны дагуу нийгмийн даатгалын байгууллагад даатгуулагч бүртгүүлсний дараагийн өдрөөс эхлэн тооцож олгоно.

3.2. “Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай”

тооцно. Тухайлбал, даатгуулагч 2014 оны 05 дугаар сарын 01-ний өдөр ажлаас халагдсан бол мөн оны 05 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад өргөдөл гаргах боломжтой.

3.3. Өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар өргөдөл гаргах боломжгүй байсан хүндэтгэх шалтгаан гэдэгт Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 33 дугаар тогтоолын 28-д заасны дагуу дараах үндэслэлийг хамруулна. Үүнд:

- а/ даатгуулагч хүндээр өвчилсэн;
- б/ хорио цээрийн дэглэм тогтоогдсон;
- в/ байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон.

3.4. Журмын 5.8-д дурдсан зайлшгүй шалтгаан гэдэгт:

- а/ даатгуулагч өвчтөн асарч байсан;
- б/ ажилтнаас хамаарахгүй шалтгаанаар ажил олгогчтой тооцоо хийх хугацаа хойшилсон;
- в/ гадаад улсад зорчсон зэрэг шалтгаан тус тус хамаарна.

Дөрөв. Бүрдүүлэх материал болон тэтгэмж олголтын талаар:

4.1. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүссэн даатгуулагч нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлийг батлагдсан маягтын дагуу гаргаж өгнө.

4.2. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) ажилгүй болсноо аймаг (дүүрэг)-ийн Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлж авсан мэдэгдэх хуудсыг даатгуулагчаас хүлээн авч, хувийн хэрэгт хадгална.

4.3. Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн банк дахь харилцах дансанд шилжүүлэх чиглэл барьж ажиллахдаа шимтгэл төлөлтийн програмаас ажилд орсон эсэхийг тухай бүр тулган шалгаж тэмдэглэл хийнэ.

4.4. Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж тооцохдоо бүтэн ажиллаагүй сүүлийн сарыг сонгож болно. Программд уг сонголтыг хийхдээ ажилгүйдлийн тэтгэмж бодох цалинг баазаас татуулахын өмнө тухайн сараас тооцох гэсэн сонголтыг идэвхжүүлбэл тухайн сараасаа цалингаа эхэлж авах, уг сонголтыг хийхгүй тохиолдолд шууд өмнөх сараас эхлэн цалин сонгодог хэлбэрээр оруулах ба харин сар алгасч сонголт хийхгүй.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2014 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Ажилгүйдлийн тэтгэмж тооцох, сургалтын зардал олгох журам”-ын хуулбар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Өргөдлийн загвар батлах тухай” 2014 оны А/72 дугаар тушаалын хуулбар, тус газраас Хөдөлмөрийн яаманд хүргүүлсэн 2014 оны 1/594 дүгээр албан тоотын хуулбарыг тус тус хавсаргав.

Хувийг Мэдээллийн технологийн төвд.


Хавсралт 6 хуудастай.

ДАРГА



Ц.Урtnасан

Ц.УРТНАСАН



ОНС-ын дарга *[Signature]*

Урьдчилсан

Салбарын дарга

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3.7 дахь заалт, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын намны саналыг тус тус үндэслэн ТОГТОХ нь.

Нэг. "Ажилгүйдлийн тэтгэмж тооцох, сургалтын зардал олгох журам"-ийг хавсралт ёсоор баталж, 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөй.

Хоёр. Ажилгүйдлийн даатгалын сангаас зарцуулах сургалтын зардалын нэг хүнд ногдох дээд хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн сургалтын зардалын жинг хэжээнд нийцүүлэн шинэчлэн тогтоох талаар тооцоо, судалгаа хийж, холбогдох байгууллагад уламжлах арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Ц.Уртнасан-т-үрэг/ болгосугай.

Гурав. Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /М.Саранчимэг/-нд даалгасугай.



ДАРГА

С.СЭРДЭНЭ

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2014 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн
10 дугаар тогтоолын хавсралт

АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ ТООЦОХ,
СУРГАЛТЫН ЗАРДАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийгмэг үндэслэл

1.1. "Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай" хуулийг хэрэгжүүлж, ажилгүйдлийн даатгалын сан (цаашид "сан" гэх)-аас даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж олгох, даатгуулагчийг чадавхи дээшлүүлэх, мэргэжил олгох сургалтад хамруулахтай холбоотой асуудлаар нийгмийн даатгалын байгууллага, даатгуулагч болон хөдөлмөрийн байгууллага хоорондын харилцаа, эрх үүргийг энэхүү жуумаар зохицуулна.

1.2. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага нь даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмж хүссэн өргөдлийг хүлээн авч бүртгэх, ажилгүйдлийн тэтгэмжийг тооцож, хугацаанд нь олгох, тэтгэмж авч буй даатгуулагч ажилд эрсэн эсэхэд хяналт тавих, ажилгүй болсон даатгуулагчийг чадавхи бэхжүүлэх, дээшлүүлэх, мэргэжлийн болон даатан сургалтад хамрагдсан тохиолдолд ажилгүйдлийн даатгалын сангаас олгох сургалтын зардлыг санхүүжүүлэх ажлыг эрхэлнэ.

1.3. Хөдөлмөрийн байгууллага ажилгүй болсон даатгуулагчийг бүртгэх, хөдөлмөрийн зах зээлийн талаар зөвлөгөө, мэдээлэлээр хэнгэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, төсөл, хөтөлбөрт хамрагдах боломжийн талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалтад хамруулах, хэрэв ажилгүйдлийн тэтгэмж авагчийг сүл чөлөөтэй ажлын байранд зуучилж ажилд оруулсан бол нийгмийн даатгалын байгууллагад тухай бүр мэдэгдэж ажиллана.

1.4. Энэхүү жуумын хэрэгжилт, сангийн хөрөнгийн зарцуулалт, ажилгүйдлийн тэтгэмж авагчийн чадавхи бэхжүүлэх, дээшлүүлэх, мэргэжлийн болон даатан сургалтын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын төв байгууллага хяналт тавина.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. "Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай" хууль-ийн 2 дугаар зүйлд заасан нөхцөл боллыг хангасан ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа өндөр насны тэтгэвэр тогтоолох эрх үүсвэрийг, хөдөлмөрийн насны ирлэнд ажилгүйдлийн тэтгэмж олгоно. Хөдөлмөрийн байгууллагад бүртгэлтэй, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ, контракт, Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөгсөөр ажиллах гэрээ, тэдгэртэй адилтгах гэрээ байгуулахаас татгалзахгүй иргэнийг "ажил хайхад бэлэн байгаа ажилгүй хүн" гэж үзнэ.

2.2. Даатгуулагч нь оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ харьяалах Нийгмийн даатгалын байгууллагад ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ гаргаж, тэтгэмжээ авна. Ажил олгогчийн тооцоо хийдэг Нийгмийн даатгалын байгууллагын харьяалах нь даатгуулагчийн оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяалаас өөр тохиолдолд даатгуулагч нийгмийн даатгалын давтарт шилжилт хийлтүүлнэ.

2.3. Үндсэн ажлаас гадна нэг ба түүнээс дээш байгууллагад ажил, албан тушаал хавсран гүйцэтгэж байсан даатгуулагч үндсэн ажлаасаа халагдсан тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмжийг олгоно. Энэ тохиолдолд даатгуулагч буцад байгууллагад ажил хавсран гүйцэтгэж, нийгмийн даатгалын шимтгэл толж байгаа нь ажилгүйдлийн тэтгэмжийг зогсоох үндэслэл болохгүй.

2.4. Даатгуулагч ажлаас халагдаж, ажил олгогчтойгоо тооцоо хийж дууссаны дараа ажилгүй болсноо оршин суугаа нутаг дэвсгэрийн Хөдөлмөрийн болон Нийгмийн даатгалын байгууллагад 14 хоногийн дотор бүртгүүлнэ. Ажил олгогч ба нийгмийн даатгалын барцаагч нь ажилгүй болсон даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийн тухай мэдээллийг олох үүрэгтэй.

2.5. Ажилгүйдлийн тэтгэмж авагч сургалтанд хамрагдсан тохиолдолд түүний ажилгүйдлийн тэтгэмжийг сургалтын хугацаанд үргэлжлүүлэн олгоно.

2.6. Ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа иргэн ажилд орвол, түүний ажилд орсон өдрөөс эхлэн ажилгүйдлийн тэтгэмжийг зогсооно.

Гурав, Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг тооцож олгох

3.1. Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан бүтэн ажилласан сүүлийн 3 сарын хөдөлмөрийн хэлс, түүнтэй адилтгах орлогоос тооцож олгоно.

3.2. Ажилгүйдлийн тэтгэмж авагчид олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжийн нийт хэмжээг тооцохдоо 1 өдөрт ногдох тэтгэмжийг тэтгэмж олгох нийт ажлын өдрийн тоогоор үржүүлнэ. Даатгуулагчийн нэг сард ногдох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг сарын ажлын дундаж өдрийн тоо 121.21-д хувааж 1 өдөрт ногдох тэтгэмжийг тооцно.

Хишээ №1. 16 жил ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, 2013 оны 03 дүгээр сард 400 000 төгрөг, 04 дүгээр сард 380 300 төгрөг, 2013 оны 05 дүгээр сард 390 000 төгрөгийн хөдөлмөрийн хэлс авч байсан, орон тооны цомжотогоор 2013 оны 06 дугаар сарын 01-нээс эхлэн ажилгүй болсон даатгуулагч "Ц"-д ажлын 76 өдрийн хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж олгоно гэвэл түүнд олговол зохих нийт ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээг дараах байдлаар тооцно. Даатгуулагч 16 жил ажилласан тул 70 хувиар тэтгэмж тооцно.

а/ Сарын дундаж хөдөлмөрийн хөлсний хэмжээ;

(400 000 төг + 380 300 төг + 390 000 төг) : 3 сар = 390 100 төгрөг.

б/ Нэг сард ногдох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль-ний 3 дүгээр аймгад авсан уурь хэмжээгээр тооцно.

380 100 төг x 70 % : 100% = 273 070 төгрөг.

в/ Ажлын 1 өдөрт ногдох ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

273 070 төг : 21.2 өдөр = 12 880.66 төгрөг.

г/ Даатгуулагч "Ц"-д олговол зохих нийт ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ:

12 880.66 төг x 76 өдөр = 978 830.16 төгрөг

3.3. Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авч байгаад ажилд орсон болон анх тэтгэмж олгохоор тогтоосон хугацаа дуусахаас өмнө ажлаас халагдаж Нийгмийн даатгалын болон Хөдөлмөрийн байгууллагад дахин бүртгүүлнэ. Нийгмийн даатгалын байгууллага нь дахин бүртгэсэн өдрөөс эхлэн үлдэх хугацаанд ногдох тэтгэмжийг урьд авч байсан хэмжээгээр нь үргэлжлүүлэн бодож олгоно.

Жишээ: Тэтгэмж авагч Б ажлын 76 хоног тэтгэмж авахаар тогтоологджээ. Тэтгэмж авагч Б нь ажлын 15 өдөр тэтгэмж авсаны дараа дахин ажилд орсод ажлын 20 өдрийн дараа орон тооны цомжотогоор халагдсан гэвэл түүнд ажлын 41 өдрийн тэтгэмж (41=76-15-20) олгоно.

3.4. Даатгуулагчийн хууль бусаар ажлаас халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоодож түүний ажилгүй байх хугацааны цалин, хөлс, орлогыг нийгмийн даатгалын шимтгэлийн хамт ажил олгогчоор нөхөн төлүүлсэн тохиолдолд тухайн даатгуулагч энэ хугацаанд авсан ажилгүйдлийн тэтгэмжээ санд буцаан төлж нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо хийнэ.

3.5. "Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлд заасан үндэслэлээр үүссэн маргааныг шийдвэрлэх, түүнчлэн ажилгүйдлийн тэтгэмж авагчийг ажилд орсон эсэхийг шалган тогтоох шаардлага гарсан үед тэтгэмж олгох хугацааг ажлын 7 хоногоор түүтэлзүүлж болно.

Дөрөв, Сургалтын зардлын санхүүжилт

4.1. Мэргэжилтэй зохил мөргөжлээ өөрчлөх, давтан сурах хүсэлт гаргасан ажилгүйдлийн тэтгэмж авагчийг ажилгүй болсноос хойш 6 сарын дотор оршин суугаа нутаг дэвсгэрийн Хөдөлмөрийн байгууллага сургалт зохион байгуулах гэрчилгээтэй мэргэжийн сургалтын байгууллагын сургалтад хамруулна. Сургалтын зардлыг ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтын байгууллагад бэлэн бусаар шилжүүлнэ.

4.2. Сургалтын хугацаа дуусахаас өмнө ажилгүйдлийн тэтгэмж авч байсан хугацаа нь дуусавар болсон тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага сургалтын зардлыг бүрэн санхүүжүүлнэ. Ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтын зардалд олгох дээд хэмжээг тухайн сургалтын төлбөр зөтсрсэн тохиолдолд зөрүү тэтгэмж авагч өөрөө хариуцана. Сургалтын төлбөрийн зөрүү урьдчилан төлсөн нөхцөлд Нийгмийн даатгалын байгууллага сургалтын төлбөл зохих төлбөрийг сургалтын байгууллагын дансанд шилжүүлнэ.

4.3. Хөдөлмөрийн байгууллага нь ажиглүүдийн тэтгэмж авагчийг сургалтад хамруулах сургалтын байгууллагагай гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хөгж, бүтэн жилээр дүн, тайлан тооцооны хамт Нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлнэ.

4.4. Ажилгүйдлийн даатгалын сангаас зарцуулах сургалтын зардлын нэг хүнд ногдох дээд хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн сургалтын зардлын жишээг хэмжээнд нийцүүлэн тухай бүр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн санхүүг үндэслэн Засгийн газар шилжчлэн тогтоосно.

Тав. Даатгуулагчийн эрх, үүрэг

5.1. Даатгуулагч ажил олгогчтойгоо тооцсо хийж дууссанаас хойш 14 хоногийн дотор ажиглүүдийн тэтгэмж авахаар дараах баримт, бичгийг бүрдүүлэн оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяалах Хөдөлмөрийн байгууллага болон Нийгмийн даатгалын байгууллагад өргөдөл гаргана.

5.1.1. Иргэний үнэмлэх, түүний хуулбар

5.1.2. Нийгмийн даатгалын дэвтэр

5.1.3. Ажлаас чөлөөлөгдсөн шийдвэр, түүний хуулбар

5.1.4. Ажилгүй болсноо Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн хуудас

5.1.5. Тэтгэмжээ бэлэн бусаар авахыг хүсвэл банкн дахь өөрийн харилцах дансны мэдээлэл

5.2. Даатгуулагч 5.1.1, 5.1.2, 5.1.3-д заасан бичиг баримтыг бүрдүүлэн оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяалах Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлж, мэдэгдэх хуудас авна.

5.3. Тэтгэмж авагч оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяалаа өөрчилсөн тохиолдолд ажиглүүдийн тэтгэмж авч байсан Нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэж, шинээр оршин суух нутаг дэвсгэрийн харьяалах Хөдөлмөрийн байгууллага, Нийгмийн даатгалын байгууллагад тус тус бүртгүүлнэ.

5.4. Ажилгүйдлийн тэтгэмж авагч нийгмийн даатгалын байгууллагаас нээсэн хувийн хэрэгтэй танкицан гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд тэтгэмжээ банкаар дамжуулан бэлнээр эсхүл өөрийн банкн дахь харилцах хадгаламж төлбөрийн картаар авах эсэхээ сонгоно.

5.5. тэтгэмж авагч өөрийн сурах сонирхолтой мэргэжлийн чиглэлээ тодорхойлож, эрх бүхий сургалтын байгууллагыг сонгон суралцана.

5.6. Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа амилд орсон тохиолдолд нийгмийн даатгалын байгууллагад мэдэгдэж, тэтгэмжээ зогсоолон нийгмийн даатгалын дэвтрээ буцаан авна.

5.7. Ажилгүйдлийн тэтгэмжийг нь зогсоосон, хэмжээг нь бууруулсан тохиолдолд нийгмийн даатгалын байгууллагаас тайлбар авах, уг тайлбарыг хүлээн зөвшөөрөхгүй бол дээд шатны байгууллага, шүүхэд гомдол гаргах эрхтэй.

5.8. Ажилгүй болсон даатгуулагч хүндэтгэх болон зайлшгүй шалтгааны улмаас энэ журмын 5.1-д заасан хугацаанд Нийгмийн даатгалын байгууллагад өргөдөл гаргаагүй тохиолдолд ажиглүүдийн тэтгэмж авах хүсэлтээ 3 сарын дотор гаргаж болно.

5.9. Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаанд сайн дурын даатгалыг хамрагдаж болно.

Зургаа. Нийгмийн даатгалын байгууллагын эрх, үүрэг

6.1. Нийгмийн даатгалын байгууллага ажилгүй болсон даатгуулагчийн өргөдлийг холбогдох бичиг баримтын хамт хүлээн авч нягтлан шалгаад тэтгэмж авагчид хувийн хэрэг нээж, олгох тэтгэмжийн хэмжээг энэ журмын 3.2-т заасны дагуу тооцож, тэтгэмж авагчид мэдэгдэнэ.

6.2. Тэтгэмж авагчид олгосон тэтгэмжийн хэмжээг сар бүр түүний хувийн хэрэгт бичин, тэтгэмж авагч дууссангуут нэг удаа нийгмийн даатгалын дэвтрээ тэмдэглэл хийж, хэрэв банкаар дамжуулан авах бол тэтгэмж олгох мэдэгдлийг даатгуулагчид олгох, тэтгэмж олголтыг сар бүр банктай тулган шалгаж, баталгаажуулна.

6.3. Ажилгүйдлийн тэтгэмж авагч хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдавал сургалтын явц болон сургалтын зардалд хяналт тавина.

6.4. Нийгмийн даатгалын төв байгууллага нь ажиглүүдийн тэтгэмж авагчийн мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлж, ажиглүүдийн тэтгэмж авч байгаа иргэн ажилд орсон эсэхэд хяналт тавих нөхцлийг хангана.

6.5. Нийгмийн даатгалын төв байгууллага нь ажиглүүдийн тэтгэмж авагчийн тэтгэмж зогсоогдсон тухай мэдээллийг Хөдөлмөрийн байгууллагад тухай бүр цахимаар мэдэгдэнэ.

6.6. Ажилгүйдлийн тэтгэмж авагч нийгмийн даатгалд сайн дураар хамрагдавал шимтгэлийн бичгийг нийгмийн даатгалын дэвтрээ хийж, тухай бүр баталгаажуулна.

6.7. Даатгуулагчаас гаргасан гомдлыг хүлээн авч зохих хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.

Долоо. Хариуцлага

7.1. Тэтгэмж авагч хуурамч бичиг баримт бүрдүүлж тэтгэмж авсан, тэтгэмж авч байх хугацаандаа амилд орсон нь нотлогдсон тохиолдолд буцаан төлүүлэх арга хэмжээ авна.

7.2. Ажилгүйдлийн тэтгэмжийг буруу тооцсон, өөр хүнд олгосон болон бүсэд эерийн гаргасан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2014 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/72

Улаанбаатар хот

Өргөдлийн загвар батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх, Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм"-ийн "Гурав" дахь хэсгийн "16"-гийн "к" заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүссэн даатгуулагчийн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д хүсэлт гаргах өргөдлийн загварыг хавсралтаар баталсугай.


2. Аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт ДААЛГАХ нь:

2.1. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт гаргасан даатгуулагчийн өргөдөл, хавсарган ирүүлсэн баримт бичгийн үндэслэл, үнэн зөвийг нягтлан шалгаж, шаардлага хангасан өргөдөл, баримт бичгийг хүлээн авч ажилгүйдлийн тэтгэмж тогтоох, олгох асуудлыг хуульд заасан хугацаанд нь чирэгдэлгүй шуурхай шийдвэрлэж ажиллах;

2.2. Даатгуулагч хуурамч бичиг баримт бүрдүүлж ажилгүйдлийн тэтгэмж авсан, ажилд орсон боловч ажилгүйдлийн тэтгэмж үргэлжлүүлэн авсан, хууль бусаар халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, ажилгүй байх хугацааны цалин хөлс, орлогыг нийгмийн даатгалын шимтгэлийн хамт ажил олгогчоор төлүүлсэн зэрэг тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчаар төлүүлэх арга хэмжээ авч, ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээний газар (Н.Ариунаа)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.УРТНАСАН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хуульчдын гудамж 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2014.04.23 № 1/594
танай _____-ны № _____-т

ХӨДӨЛМӨРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
П.ГАНТУЛГА ТАНАА

Хамтран ажиллах тухай

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2014 оны 10 дугаар тогтоолоор "Ажилгүйдлийн тэтгэмж тооцох, сургалтын зардал олгох журам"-ыг баталсан юм.


Иймд уг журамд заасан хөдөлмөрийн байгууллагын хариуцах чиг үүргийг хэрэгжүүлэн хамтран ажиллахыг хүсье.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2014 оны 10 дугаар тогтоолоор баталсан "Ажилгүйдлийн тэтгэмж тооцох, сургалтын зардал олгох журам"-ын хуулбарыг хавсаргав.

Хавсралт 3 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Ц.УРТНАСАН